

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/16/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 51-261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшсүрэн Утас: 51-261740 Цахим хаяг: tegshsurenb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.6 Худалдан авах, ажиллагааны гүйцэтгэл	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар.....	21
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Төлбөрийн акт.....	23
5.2 Албан шаардлага	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮЦЗЗ	Үнэт цаасны зах зээл
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал
ҮХХЗҮЭЗГ	Үл хөдлөх хөрөнгө зуучлал, Үнэт эдлэл зохицуулалтын газар
ҮЦЗЗ	Үнэт цаасны зах зээл



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА Т.ЖАМБААЖАМЦ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.24 № 1133
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд батлагдсан, хорооны тайлант онд улсын төсөв болон өөрийн орлогын эх үүсвэрийн санхүүжилтээр хэрэгжсэн дараах ажлыг онцолж байна. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан, Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх журмаар хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад үнэт цаас зээлдүүлэх боломжийг нээсэн зохицуулалтыг баталсан;
- Биржийн бус зах зээлийн блокчэйд суурилсан арилжааны платформ зах зээлд бүрэн нэвтэрч арилжаа, төлбөр тооцоог 24/5 цагийн горимоор ил тод, тасралтгүй гүйцэтгэх боломж бүрдсэн;
- Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх тухай” 480 дугаар тогтоолоор санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар алтны үнийн хөдөлгөөнөөс өгөөж болон эрсдэлийг нэгж эрх эзэмшигчдэд хүртээхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын сан байгуулагдсан;

- Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан;
- Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 116 дугаар тогтоолоор “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д олон улсын санхүүгийн байгууллагаас өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулснаар олон улсын санхүүгийн байгууллагаас дотоодын хөрөнгийн зах зээлд бонд гаргах боломж бүрдсэн;
- Санхүүгийн зохицуулах хорооны 500 дугаар тогтоолоор даатгалын компаниудын гаргах баталгааны дээд хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэн;
- Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, иргэд олон нийтийг өрийн дарамтад орохоос сэргийлэх зорилгоор банк бус санхүүгийн байгууллагуудаас олгож буй хэрэглээний зээлийн бүтээгдэхүүний өр орлогын харьцааг 60.0 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосон байна.

Мөн Санхүүгийн зохицуулах хороо нь 2023 онд үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 4,734.9 сая төгрөгт хүрч, батлагдсан төсвөөс 73.0 хувиар, 2024 онд 4,924.9 сая төгрөгт хүрч 79.9 хувиар, 2025 онд 4,669.0 сая төгрөгт хүрч 16.7 хувиар тус тус давсан байна. Ийнхүү 2023-2024 онуудад орлогын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс өндөр зөрүүтэй давсан байсан бол 2025 онд уг зөрүү мэдэгдэхүйц буурсан нь орлогын төлөвлөлт өмнөх онуудтай харьцуулахад илүү бодитой, үндэслэлтэй болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтээр төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэл тоон үзүүлэлтээр хангагдсан, батлагдсан төсвийн гүйцэтгэл 87.9 хувьтай байгаа боловч хорооны үйл ажиллагааны голлох үзүүлэлтийг илэрхийлэх мэдээлэл сурталчилгааны зардлын гүйцэтгэл 27.7 хувь, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа арга хэмжээний гүйцэтгэл 44.2 хувьтай нь байгаа нь удирдлага, зохицуулалтын шинэчлэл, зах зээлийн чанарын үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, санхүүжилтийн зарцуулалтын үр ашиг, бодлогын үр дүнгийн уялдаа хангалтгүй байх эрсдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,622,432.0	2,431,559.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	603,297.5	12,169.7
33	АВЛАГА	423.1	1,222,030.7
34	УРЬДЧИЛГАА	566,669.6	35,241.4
35	БАРАА МАТЕРИАЛ	330,201.9	329,317.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,121,840.0	832,800.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,857,411.0	2,941,430.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,857,411.0	2,941,430.9
39200	Биет хөрөнгө	2,673,699.0	2,474,361.9
39300	Биет бус хөрөнгө	183,712.0	467,069.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,479,843.0	5,372,990.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	455,693.5	361,268.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	455,693.5	361,268.3
41300	Өглөг	455,600.0	361,268.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,024,149.5	5,011,721.8
51	Засгийн газрын хувь оролцоо	5,024,149.5	5,011,721.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	590,228.9	590,228.9
51200	Хуримтлагдсан үр дүн	4,433,920.5	4,396,492.9
51300	Дахин үнэлгээний зөрүү		25,000.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,479,843.0	5,372,990.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,819,434.0	22,215,680.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	82,068.0	38,064.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	82,068.0	38,064.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,102,436.9	22,177,615.9
120	Нийтлэг татварын бус орлого	6,102,436.9	6,218,960.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,424,591.5	15,958,655.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,276,972.6	22,277,420.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,821,372.6	22,277,420.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,608,401.9	19,051,312.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,459,800.2	13,881,488.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	949,274.0	1,752,146.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,778.2	9,878.0
2104	Хангамж, бараа материалын зардал	138,485.8	168,402.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,252.0	2,654.6
2107	Томилолт, зочны зардал	198,797.6	283,095.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,358,259.0	2,282,259.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	487,755.0	671,386.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,212,970.7	3,226,107.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	455,600.0	243,394.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	542,461.4	(61,739.8)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	542,461.4	(61,739.8)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		16,322,080.5	22,108,323.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО		83,478.0	38,514.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		83,478.0	38,514.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		83,478.0	38,514.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,417,092.3	22,069,809.2
120	Нийтлэг татварын бус орлого		4,417,092.3	6,111,153.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		11,821,510.2	15,958,655.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		14,464,691.8	21,909,735.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		14,464,691.8	21,909,735.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		11,253,441.1	17,660,092.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		7,375,454.4	13,946,369.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		932,146.9	1,687,344.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		71,343.3	64,062.3
2104	Хангамж, бараа материалын зардал		42,256.1	56,100.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		132.0	1,086.6
2107	Томилолт, зочны зардал		198,797.6	177,319.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,632,722.7	1,720,740.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		588.0	7,069.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,211,250.7	4,249,642.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		1,857,388.7	198,588.5
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		1,350,256.7	698,994.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		1,350,256.7	698,994.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,350,256.7	698,994.8
2200	Дотоод эх үүсвэрээр		1,350,256.7	698,994.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(1,350,256.7)	(698,994.8)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		-	90,721.4
250006	Бусад зардал		-	90,721.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-	(90,721.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		507,132.0	(591,127.7)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		96,165.5	603,297.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		603,297.5	12,169.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,481,718.2	-	4,481,718.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,481,718.2	-	4,481,718.2
9	Тайлант үеийн үр дүн	542,431.3	-	542,431.3
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,024,149.5	-	5,024,149.5
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,024,149.5	-	5,024,149.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,073,461.6	-	5,073,461.6
19	Тайлант үеийн үр дүн	(61,739.8)	-	(61,739.8)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,011,721.8	-	5,011,721.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	20,920,456,900.00	19,237,203,111.35	1,683,253,788.65	91.9
12	Татварын бус орлого	20,920,456,900.00	19,237,203,111.35	1,683,253,788.65	91.9
120	Нийтлэг татварын бус орлого	4,000,000,000.00	4,669,000,645.04	(669,000,645.04)	116.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	4,000,000,000.00	4,669,000,645.04	(669,000,645.04)	116.7
122	Тусламжийн орлого	16,920,456,900.00	14,568,202,466.31	2,352,254,433.69	86.1
122005	Төсвөөс санхүүжих	16,920,456,900.00	14,568,202,466.31	2,352,254,433.69	86.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,920,456,900.00	18,378,244,600.56	2,542,212,299.44	87.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,677,056,900.00	18,134,849,800.56	2,542,212,299.44	87.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,064,452,600.00	17,542,989,808.56	2,521,462,791.44	87.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,718,993,200.00	13,946,369,362.63	772,623,837.37	94.8
210101	Үндсэн цалин	5,654,323,200.00	6,087,454,626.48	(433,131,426.48)	107.7
210102	Нэмэгдэл	5,612,299,100.00	4,171,769,539.88	1,440,529,560.12	74.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,253,078,500.00	1,249,756,882.88	3,321,617.12	99.7
210104	Урамшуулал	2,199,292,400.00	2,437,388,313.39	(238,095,913.39)	110.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,806,336,700.00	1,687,344,484.09	118,992,215.91	93.4
210201	Тэтгэврийн даатгал	1,247,697,200.00	1,130,437,784.09	117,259,415.91	90.6
210202	Тэтгэмжийн даатгал	139,659,800.00	139,659,800.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	69,830,000.00	69,830,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	69,830,000.00	69,830,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	279,319,700.00	277,586,900.00	1,732,800.00	99.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,276,600.00	64,062,300.00	2,214,300.00	96.7
210304	Байрны түрээс	66,276,600.00	64,062,300.00	2,214,300.00	96.7
2104	Хангамж, бараа материалын зардал	190,395,700.00	56,100,770.00	134,294,930.00	29.5
210401	Бичиг хэрэг	104,587,100.00	10,911,000.00	93,676,100.00	10.4
210402	Тээвэр, шатахуун	26,973,500.00	12,386,153.00	14,587,347.00	45.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,238,900.00	26,084,251.00	6,154,649.00	80.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,596,200.00	6,719,366.00	19,876,834.00	25.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,131,900.00	1,086,562.00	5,045,338.00	17.7

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	6,131,900.00	1,086,562.00	5,045,338.00	17.7
2107	Томилолт, зочны зардал	97,995,400.00	85,689,154.00	12,306,246.00	87.4
210701	Гадаад албан томилолт	50,152,500.00	47,795,680.00	2,356,820.00	95.3
210702	Дотоод албан томилолт	47,842,900.00	37,893,474.00	9,949,426.00	79.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,159,818,100.00	1,695,267,975.84	1,464,550,124.16	53.7
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,058,253,900.00	1,632,898,410.34	1,425,355,489.66	53.4
210803	Даатгалын үйлчилгээ	6,511,900.00	5,256,600.00	1,255,300.00	80.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,122,000.00	832,635.50	289,364.50	74.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	37,400.00	37,300.00	100.00	99.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,017,800.00	24,173,100.00	3,844,700.00	86.3
210807	Газрын төлбөр	153,500.00	137,130.00	16,370.00	89.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	65,721,600.00	31,932,800.00	33,788,800.00	48.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,505,000.00	7,069,200.00	11,435,800.00	38.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,505,000.00	7,069,200.00	11,435,800.00	38.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	612,604,300.00	591,859,992.00	20,744,308.00	96.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	447,682,500.00	447,682,500.00	-	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	447,682,500.00	447,682,500.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	164,921,800.00	144,177,492.00	20,744,308.00	87.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	132,935,600.00	132,935,492.00	108.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,986,200.00	11,242,000.00	20,744,200.00	35.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	243,400,000.00	243,394,800.00	5,200.00	100.0
220001	Барилга байгууламж	243,400,000.00	243,394,800.00	5,200.00	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	858,958,510.79	(858,958,510.79)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(858,958,510.79)	858,958,510.79	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(858,958,510.79)	858,958,510.79	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	362	362	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	180	180	-	100.0
620001	Удирдах ажилтан	22	22	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	153	153	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	180	180	-	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	170	170	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3	-	100.0
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	2	2	-	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	2	2	-	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	2	2	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		91,629,975.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		91,629,975.50
122	Тусламжийн орлого		91,629,975.50
1221	Хандив тусламж /дотоод/		91,629,975.50
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		91,629,975.50
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		82,662,575.50
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		8,967,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		91,629,975.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		91,629,975.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		91,629,975.50
2107	Томилолт, зочны зардал		91,629,975.50
210701	Гадаад албан томилолт		91,629,975.50

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Олон тулгуурт, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Дээрх зорилгыг хэрэгжүүлж ажиллахын тулд хорооны 2022-2025 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Зохицуулалтын салбарын эрх зүйн орчин, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц сайжирч, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжих орчин бүрдэж, эрсдэлд суурилсан болон нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоо нэвтэрч, санхүүгийн салбарын тогтвортой байдал хангагдаж санхүүгийн зах зээл тэлнэ.
- Санхүүгийн зах зээлд дэвшилтэт технологи нэвтэрч, зах зээлийн хүртээмж нэмэгдэж, нээлттэй, ил тод байдал, хариуцлага сайжирч, хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалагдсан, иргэдийн зах зээлд итгэх итгэл нэмэгдсэн байна.
- Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, байгууллагын соёл төлөвшин, хамтын ажиллагаа өргөжсөн, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байна.

Тайлант онд Санхүүгийн зах зээлийн тогтвортой хөгжлийг хангах, зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг олон улсын түвшинд гаргах, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр цогц арга хэмжээнүүдийг үе шаттай хэрэгжүүлэн ажилласан байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д *"төсвийн ерөнхийлөн захирагч"* гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг" гэж заасны дагуу Монгол Улсын их хурлын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор томилогдсон Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц нь төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Санхүүгийн зохицуулах хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг мөрдөн ажиллаж байна.

Зохицуулалттай санхүүгийн салбарын мэргэжлийн үйл ажиллагааны зохицуулалтын орчныг зах зээлийн хөгжилтэй нийцүүлэн сайжруулах болон шинээр батлагдсан эрх зүйн орчинтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг батлах чиглэлээр тус хороо нь тайлант онд 4 журмыг шинээр, 14 журмыг шинэчлэн баталж, 7 журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны дотоод аудитын хэлтсээс тайлант онд дараах ажлуудыг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган жилийн эцэст гүйцэтгэлээ тайлагнасан байна.

- Хорооны стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тогтоол, тушаал шийдвэрийн хэрэгжилтэд системчилсэн үнэлгээ хийх;
- Урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн газар нэгжүүдийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, аудитад хамрагдах шаардлагатай объектуудыг тодорхойлсны үр дүнд хамгийн их эрсдэлтэйд тооцсон асуудалд аудит хийх;
- Төсвийн хөрөнгөөр хийгдэж буй үйл ажиллагаа болон орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, төсвийн санхүүжилт, зориулалт, түүний үр ашигтай байдал;

- Төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал, өмнөх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2025 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалттай холбоотой 29 хууль, 51 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 240 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлах тухай” 354 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус хорооны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 5,373.0 сая төгрөг болж өмнөх оноос 106.9 сая төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	603,297.5	12,169.8	(591,127.7)
Авлага	423.1	1,222,030.7	1,221,607.6
Урьдчилгаа	566,669.5	35,241.4	(531,428.1)
Бараа материал	330,201.9	329,317.3	(884.5)
Бусад эргэлтийн хөрөнгө	1,121,840.0	832,800.0	(289,040.0)
Үндсэн хөрөнгө	2,857,411.0	2,941,430.9	84,020.0
Нийт хөрөнгө	5,479,843.0	5,372,990.1	(106,852.9)
Өглөг	455,693.5	361,268.3	(94,425.2)
Засгийн газрын хувь оролцоо	5,024,149.5	5,011,721.8	(12,427.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,479,843.0	5,372,990.1	(106,852.9)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данстууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 12.2 сая төгрөг болж, өмнөх оноос 591.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах/Хөрөнгө оруулалтын барьцаа данс	603,297.5	12,169.7	(591,127.8)
Дүн	603,297.5	12,169.7	(591,127.8)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа дансанд төвлөрүүлсэн 455.6 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгож, ахмадын сангийн өмнөх оны үлдэгдэл 147.7 сая төгрөг, тайлант онд 7.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 64.8 сая төгрөгийг зарцуулж, 90.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн татаас санхүүжилтийн авлагаар бүртгэснээс шалтгаалж мөнгөн хөрөнгө 591.1 сая төгрөгөөр буурсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлант оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн баталгааны барьцаа 5 хувийг суутган хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулснаас үлдэгдэл 12.2 сая төгрөг бүртгэлтэй байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,222.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,221.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	322.9	307.6	(15.3)
Татаас, санхүүжилтийн авлага	-	1,074,327.4	1,074,327.4
Байгууллагаас авах авлага	-	147,395.8	147,395.8
Бусад авлага	100.2	-	(100.2)
Дүн	423.1	1,222,030.8	1,221,607.7

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлагын дансны үлдэгдэл өсөхөд татаас санхүүжилтийн авлага 1,074.3 сая төгрөг, байгууллагаас авах 147.4 сая төгрөгийн авлагыг бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Татаас санхүүжилтийн авлагад төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн үлдэгдэл 113.4 сая төгрөг, Сангийн сайдын 2026 оны “Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай” 24 дүгээр тушаалаар 669.0 сая төгрөг, ахмадын сангийн үлдэгдэл 90.7 сая төгрөг, тэмдэгтийн хураамжийн орлогын 10.9 сая төгрөг, үндсэн данснаас төвлөрүүлсэн 190.3 сая төгрөг, нийт 1,074.3 сая төгрөг, байгууллагаас авах авлагад банк бус санхүүгийн 2 байгууллагын 3.5 сая төгрөг, мөнгөн зээлийн зах зээлийн оролцогч 16 аж ахуйн нэгжийн 9.6 сая төгрөг, даатгалын 1 аж ахуйн нэгжийн 0.3 сая төгрөг, ҮЦЗЗ-ын 17 оролцогчийн 134.0 сая төгрөг, нийт 147.4 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 35.2 сая төгрөг болж, өмнөх оноос 531.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	566,669.6	35,241.4	(531,428.2)
Дүн	566,669.6	35,241.4	(531,428.2)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2024 оны хөрөнгийн зардал 455.6 сая төгрөгийг урьдчилгаа дансанд бүртгэсэн байсан нь хэрэгжиж 285.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 170.1 сая төгрөгийн программ хангамжийг орлогод авч урьдчилгаа дансны үлдэгдэл буурсан байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 329.3 сая төгрөг болж, өмнөх оноос 0.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	19,114.2	19,114.2	-
Бэлэн бүтээгдэхүүн	265.0	994.0	729.0
Бичиг хэргийн материал	179,418.7	172,241.5	(7,177.2)
Аж ахуйн материал	77,491.9	80,564.2	3,072.3
Сэлбэг хэрэгсэл	5,533.2	7,085.2	1,552.0
Түлш, шатах тослох материал	256.0	1,000.0	744.0
Бусад хангамжийн материал	48,122.9	48,318.3	195.4
Дүн	330,201.9	329,317.4	(884.5)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 0.9 сая төгрөгөөр буурсан бөгөөд уг бууралтад бичиг хэргийн материалын үлдэгдэл 7.2 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Тайлант онд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд нийт 217.2 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, 218.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 832.8 сая төгрөг болж, өмнөх оноос 289.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	1,121,840.0	832,800.0	(289,040.0)
Дүн	1,121,840.0	832,800.0	(289,040.0)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бусад эргэлтийн хөрөнгө данс 289.0 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд худалдан авсан 455.6 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, программ хангамжийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалсан бол Монгол банктай байгуулсан 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн “Үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх” 03-03-0221/62 тоот гэрээний дагуу тус байгууллагын ашиглаж байгаа байрны 166.6 сая төгрөгийн тайлант оны төлбөрийн дүнгээр нэмэгдсэн байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэлд Үндэсний цахим гүйлгээний төвийн 2021-2025 оны түрээсийн төлбөрийн 5 жилд хуримтлуулан бүртгэсэн 832.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,941.4 сая төгрөг болж, өмнөх оноос 84.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Тээврийн хэрэгсэл	38,841.7	319,318.5	280,476.8
Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,345,729.3	1,918,096.0	(427,633.3)
Тавилга, аж ахуйн эд хогшил	289,128.0	236,947.5	(52,180.5)
Программ хангамж	170,810.2	445,892.5	275,082.3
Биет бус хөрөнгө	12,901.8	21,176.5	8,274.7
Дүн	2,857,411.0	2,941,431.0	84,020.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 84.0 сая төгрөгөөр өссөн нь 368.1 сая төгрөгийн программ хангамж, 285.5 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 45.4 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдан авсан, 25.0 сая төгрөгөөр авто тээврийн хэрэгсэл дахин үнэлсэнтэй холбоотой байна. Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 448 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгож, нийт 537 нэрийн 749 ширхэг 387.9 сая төгрөгийн хөрөнгө акталсан байна.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 361.3 сая сая төгрөг болж, өмнөх оноос 94.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	455,600.0	361,268.3	(94,331.7)
Татварын өглөг	93.5	-	(93.5)
Дүн	455,693.5	361,268.3	(94,425.2)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оноос нийт 94.4 сая төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өглөг болон татварын өглөгийн бууралтаас шалтгаалсан. Тухайлбал, 2024 онд хөрөнгө бэлтгэсэн 455.6 сая төгрөгийн өглөгийг тайлант онд төлж барагдуулсан байна. Тайлант оны эцэст төсвийн санхүүжилт бүрэн тавигдаагүйгээс 361.3 сая төгрөгийн байгууллагад төлөх өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,011.7 сая төгрөг болж, өмнөх оноос 12.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хуримтлагдсан үр дүн	4,433,920.5	4,396,492.9	(37,427.6)
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	590,228.9	590,228.9	-
Дахин үнэлгээний зөрүү	-	25,000.0	25,000.0
Дүн	5,024,149.4	5,011,721.8	(12,427.6)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 12.4 сая төгрөгөөр буурсан нь авто тээврийн хэрэгсэл дахин үнэлсэн болон тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 23,193.0 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 22,943.0 сая төгрөг, хөрөнгийн зардалд 250.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж УИХ-аас нийт төсвийг 21,703.7 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 783.3 сая төгрөг хасагдаж урсгал зардлыг 20,677.1 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 243.3 сая төгрөг, нийт 20,920.4 сая төгрөг баталсан байна.

Цалин хөдөлмөрийн хөлс, нийгмийн даатгалын зардал 410.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 2.1 сая төгрөг, томилолт зочны зардал 17.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 328.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1.1 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 17.0 сая төгрөг, хөрөнгийн зардал 6.6 сая төгрөгөөр тус тус буурч батлагдсан.

Санхүүгийн зохицуулах хорооны зардлын дээд хязгаарыг давсан шалтгаан нь хорооны ажлын албаны бүтцэд шинээр 2 албыг байгуулахтай холбогдуулан нийт 25 орон тоо нэмэгдүүлэх санал өгсөн ба шинээр нэмэгдэж байгаа орон тоонд хамаарах цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад нийгмийн баталгааг хангахад зориулах нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж олгох зардал, байр ашиглалттай холбоотой метр квадратын зардал өмнөх оноос нэмэгдсэн, тэтгэвэрт гарах хүсэлтээ өгсөн 2 төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгохтой холбоотой зардлыг тусгасан, олон улсын гишүүн байгууллагын төлбөр хураамжийн гадаад валютын ханшийн зөрүү, орон нутгийн хяналт шалгалтын албан томилолтууд нэмэгдсэн зэрэг нөлөө үзүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний 4 зорилго, 9 зорилт, 75 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн 80.9 хувь буюу 16,920.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 19.1 хувь буюу 4,000.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр батлагдсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-д заасны дагуу Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр төсөвт 9 удаагийн 3,461.2 сая төгрөгийн зохицуулалт хийж, зардлын эдийн засгийн ангилал шилжүүлж, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн орлого бүрдүүлэлтийн талаар:

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 4,000.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас 4,669.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 669.0 сая төгрөг буюу 17.0 хувиар давсан биелэлттэй байна.

Хүснэгт 10. Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Банк бус санхүүгийн байгууллага	1,360,211.0	1,511,305.3	151,094.3	111.1
Даатгалын чиглэл	1,065,255.3	1,079,301.3	14,046	101.3
Үнэт цаасны чиглэл	1,449,749.7	1,759,745.1	309,995.4	121.4
Хадгаламж, зээлийн хоршоо	27,250.0	42,190.0	14,940.0	154.8
ҮХХЗҮЭЗ	50,000.0	74,650.0	24,650.0	149.3
Виртуал хөрөнгө	20,000.0	167,929.9	147,929.9	839.6
Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч	27,534.0	33,660.0	6,126.0	122.2
Бусад орлого	-	219.0	219.0	-
Нийт дүн	4,000,000.0	4,669,000.6	669,000.6	116.7

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Санхүүгийн зохицуулах хорооны журмаар тогтоосон тогтмол үнийн дүнд үндэслэн салбар бүрийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцон төлөвлөсөн байна. Харин тогтмол бус дүнгээр тооцож төвлөрүүлдэг орлогын хувьд зах зээлийн нөхцөл байдал болон өмнөх жилүүдийн өсөлтийн хандлагыг харгалзан орлогыг нэмэгдүүлэн тооцжээ. Гүйцэтгэлээр орлогын 8 төрөл төлөвлөсөн түвшнээс давж биелсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 15,753.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 4,669.0 сая төгрөг, нийт 20,422.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 18,134.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 243.4 сая төгрөгийг зарцуулж, 2,044.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэл 18,378.2 сая төгрөг буюу 87.8 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 15,633.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 681.4 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 56.1 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 1.1 сая төгрөг, томилолт зочны зардалд 85.7 сая төгрөг, нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 62.3 сая төгрөг, мэргэжлийн үйлчилгээний төлбөрт 977.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 44.7 сая төгрөг, засгийн газрын урсгал шилжүүлэгт 447.7 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 144.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 243.4 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэл дутуу зарцуулахад мэргэжлийн үйлчилгээний төлбөр болох мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн батлагдсан төсвийг сар, улирлын хуваарьт өөрчлөлт орж 5 болон 11 дүгээр саруудад улсын төсвийн орлого бүрдэлттэй холбоотой санхүүжилтийн эрэмбэлэгдэж, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Ерөнхий сайдын захирамжийн дагуу хэмнэлтийн горимд шилжиж сургалт, хэлэлцүүлэг форум, гадаад болон дотоод томилолт бусад төлөвлөгөөт ажлууд хийгдээгүй зэрэг нөлөөлсөн байна. Тухайлбал, сургалт, хэлэлцүүлэг форум, гадаад болон дотоод томилолт бусад төлөвлөгөөт ажлууд хийгдээгүй зэрэг шалтгааны улмаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 97.5 сая төгрөг, хангамжийн бараа материалын зардлыг 134.3 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 5.0 сая төгрөг, томилолт зочны зардлыг 12.3 сая төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 20.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 109.6 сая төгрөг, нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 1,271.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70204	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт	20,920,456.9	18,378,249.8	2,542,207.1	87.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	16,939,922.1	15,846,029.1	1,093,893.0	93.5
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	135,786.1	37,612.2	98,173.9	27.7
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардал	-	-	-	-
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	778,942.9	681,441.1	97,501.8	87.5
80509	Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	447,682.5	447,682.5	-	100.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	164,921.8	144,177.5	20,744.3	87.4
82324	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	2,209,801.5	977,907.4	1,231,894.1	44.2
80918	Бусад хөрөнгө оруулалт	243,400.0	243,400.0	-	100.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 4 арга хэмжээний зорилтод түвшний биелэлт 100 хувьтай тайлагнасан байна.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжих хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2025 оны зорилтод түвшин	2025 онд хүрсэн түвшин
12	70204 Санхүүгийн зохицуулах хорооны дарга		
	12.1.1 Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.	14	18
	12.1.2 Банкнаас бусад санхүүгийн салбарын эрсдэлийн үнэлгээг сайжруулах тогтолцоог бэхжүүлнэ.	190	659
	12.1.3 Санхүүгийн зах зээлийн судалгаа, шинжилгээг сайжруулна.	10	11
	12.1.4 Зохицуулалттай салбараас оролцогчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлнэ.	2450	3488

Тайлант онд Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд 4 журмыг шинээр, 14 журмыг шинэчлэн баталж, зохицуулалттай этгээдэд 659 удаагийн газар дээрх хяналт шалгалт, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-аар 2,311 этгээдийн эрсдэлийн үнэлгээг хийж байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нийт 11 төрлийн судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй;
- Ажлын албаны даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны Б/150 дугаар тушаалаар хорооны албан хаагчдын хоолны зардлыг ажлын нэг өдөрт 32.0 мянган төгрөг, унааны зардлыг 3.0 мянган төгрөгөөр тогтоосон;
- Сургалт, семинар, хурал зөвлөгөөнтэй холбоотой арга хэмжээний 174.7 сая төгрөгийн төсөв төлөвлөж, сургалт семинарын 27 арга хэмжээний зардалд 139.9 сая төгрөг,

хурал, зөвлөгөөн, түүнтэй адилтгах 6 арга хэмжээний зардалд 34.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан;

- Гадаад албан томилолтын зардалд 162.5 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэл 141.7 сая төгрөг, зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 26.9 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэл 17.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг 10 байгууллагатай 97.7 сая төгрөгийн гэрээ байгуулж иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах гэрээт ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтийн дансанд хандив, тусламжаар Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс (AFI) сургалтын албан томилолтын зардалд 205.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтад оролцогчдын нислэгийн тийзийн зардалд 91.6 сая төгрөгийг зарцуулж, 113.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж тайлагнасан.

3.6 Худалдан авах, ажиллагааны гүйцэтгэл

Төсвийг ерөнхийлөн захирагчийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1 арга хэмжээний 250.0 сая төгрөг, урсгал зардлаас санхүүжүүлэх 7 арга хэмжээнд 395.7 сая төгрөг нийт 8 арга хэмээг хэрэгжүүлэхээр 645.7 сая төгрөг баталсан байна.

Гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж 1 аж ахуйн нэгжтэй 243.4 сая төгрөг, урсгал санхүүжилтээс 5 худалдан авалтыг харьцуулалтын аргаар хэрэгжүүлж 86.3 сая төгрөг, ерөнхий гэрээгээр 1 худалдан авах ажиллагаа зохион байгуулж 122.0 сая төгрөг, нийт 433.1 сая төгрөгийн гэрээг 7 аж ахуйн нэгжтэй байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах цалин урамшуулал, бүтэц орон тоо, үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитор Б.Тэгшсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хороо 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/1220 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 15,277.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 152.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 22,277.4 сая төгрөг болж, 2024 оноос 45.8 хувиар нэмэгдсэн нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзлээ.

Материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 22,277.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 222.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 10.8 сая төгрөгийн зөрчил илэрч, 6.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.6 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар илэрсэн нийт 264.7 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 245.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 19.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 24,440.7 сая төгрөгийн орлогын 244 гүйлгээ, 7,165.3 сая төгрөгийн зардлын 126 гүйлгээг цаг хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн “Жилийн эцсийн урамшуулал олгох тухай” Б/233 дугаар тушаалаар 312.8 сая төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохдоо албан хаагчдын жилийн гүйцэтгэлийн үнэлгээг байгууллагын гүйцэтгэлийн тайлагнал, үнэлгээ баталгаажих хугацаатай уялдуулан бодитой, үндэслэлтэй үнэлээгүй байна. Тухайлбал, 2025 оны 12 дугаар сард хэрэгжихээр төлөвлөгдсөн, тухайн хугацаанд бодит гүйцэтгэл нь гараагүй ажлуудыг бүрэн хэрэгжсэн гэж урьдчилан үнэлж, жилийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2-т Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно:”, 2.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.”, 2.4-д “Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална.”, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 1.2-т “Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхдээ Төрийн албаны тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан зарчмаас гадна нотолгоонд суурилсан, бодитой, шударга байх зарчмыг баримтална.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг улирлын эцэст гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан ажлуудыг бүрэн хэрэгжиж дууссаны дараа бодитой үнэлж олгож байх.

Илрүүлэлт 2: Санхүүгийн зохицуулах хороо нь тайлант онд бүтэц, орон тоог бууруулах талаар өгөгдсөн чиглэлийг хэрэгжүүлээгүй, “Талант Бридж партнерс” ХХК-аас 19.0 сая төгрөгийн зөвлөн туслах үйлчилгээ авч судалгаа хийлгэсэн боловч түүний үр дүн, зөвлөмжийг ашиглаагүй, цалингийн төсвийг тодотголоор бууруулсантай уялдуулан орон тооны зохицуулалт хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Бүтэц, орон тоог бууруулах талаар дээд шатны байгууллагаас өгсөн чиглэлийг хэрэгжүүлж, цалингийн санд багтаан орон тооны зохицуулалтыг бодитой хийх, зөвлөн туслах үйлчилгээний үр дүн, зөвлөмжийг үйл ажиллагаандаа ашиглах.

Илрүүлэлт 3: Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчид нь “АА” ангиллаар цалинждаг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэмд байцаагч нарт сар бүр урамшуулал олгох зохицуулалт байхгүй байхад Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын байцаагчийн урамшуулал олгох журам”-ын дагуу сар бүр 15.0-30.0 хувийн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгож байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;”, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.”, 45 дугаар зүйлийн 45.1-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн зарлагын хэмнэлтэд тооцно.”, 45.1.5-д “энэ хуулийн 14.2.12, 16.5.9-т заасны дагуу зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн тогтоосны улмаас орон тоо буурсан бол түүнд ногдох цалин хөлс, бусад урсгал зардлын үлдэгдэл” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байцаагч нарт сар бүр үндэслэлгүйгээр урамшуулал олгож, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Засгийн газраас баталсан улсын төсвөөс татварыг нь төлөх олон улсын байгууллагын жагсаалтад тусгагдаагүй байгууллагын гишүүнчлэлийн төлбөрт 245.7 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөс төлсөн байна.

Энэ нь Засгийн газрын 2007 оны 60 дугаар тогтоолоор баталсан "Олон улсын байгууллага, гэрээ, конвенцын итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай" тогтоолын Хавсралт 1 "Татварыг нь улсын төсвөөс төлөх олон улсын байгууллагуудын жагсаалт", 4-т "Цаашид олон улсын байгууллагад элсэх, олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орохдоо тухайн байгууллага, гэрээ, конвенцын ач холбогдол, хамтын ажиллагааны үр өгөөжийг сайтар судалж, гишүүний татвар, хандивыг Сангийн яамны саналыг үндэслэн улсын төсвөөс гаргах тохиолдолд энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагын шийдвэрээр зөвшөөрөгдөж, жагсаалтад батлагдаагүй олон улсын байгууллагад гишүүнчлэлийн хураамж төлдөг зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн дээрх асуудлууд хууль тогтоомжийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар илрүүлсэн 331.5 сая төгрөгийн алдаа, зөрчил бүхий асуудлын бүртгэлийг боловсруулж, 2 албан шаардлагыг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 1,273.1 сая төгрөгийн 2 албан шаардлага бүрэн хэрэгжсэн, 7,419.4 сая төгрөгийн 3 зөвлөмжөөс өгснөөс 7,410.0 сая төгрөгийн 2 зөвлөмж хэрэгжиж, хэрэгжилт хангалтгүй 1, нийт шийдвэрийн биелэлт 80.0 хувьтай байна.

Хүснэгт 13. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	1,273,068.6	2	1,273,068.6	100.0
Зөвлөмж	3	7,419,433.2	2	7,410,071.3	70.0
Нийт дүн	5	8,692,501.8	4	8,683,139.9	80.0

Өмнөх аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн батлагдсан зардлыг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан тухай зөрчил давтагдан гарсан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”, “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-ыг төсвийн гүйцэтгэл, тайлагналдаа хэрэгжүүлж ажилласан эсэх;
- Харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоог зохих журмын дагуу тухай бүр тооцоо нийлж, акт үйлдэн баталгаажуулж байгаа эсэхийг тулган баталгаажуулах.

Мөн Засгийн газрын 2024 оны “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн төслийн хязгаар батлах тухай” 10 дугаар тогтоолын хавсралтаар Санхүүгийн зохицуулах хорооны тайлант онд зарцуулах урсгал зардлын дээд хэмжээг 13,913.1 сая төгрөгөөр баталсан боловч төсвийн ерөнхийлөн захирагч 9,029.9 сая төгрөгөөр давуулан хүргүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 14.2.1-д “жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;” гэж заасантай нийцэхгүй, Улсын Их Хурал хязгаараас 7,790.6 сая төгрөгөөр хэтрүүлэн анхны төсвийг баталсан байгаа асуудлыг Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар үзэх шаардлагатай гэж үзсэн болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 154.2 сая төгрөгийн 4 зөрчил¹ илэрсэнд 6.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 143.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 4.6 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 154.2 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 68.6 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Шагнал, урамшуулалтай холбоотой нийт 6.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн Б/219 дүгээр тушаалаар ажил байдлын тодорхойлолтод заагдаагүй, үндсэн чиг үүрэгт хамааралгүй асуудлаар 1 албан хаагчид үндэслэлгүй 1 сарын цалин буюу 3.3 сая төгрөгийн урамшуулал олгосон;
- Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Б/245 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан 1 албан хаагчид жилийн эцсийн урамшуулал шагнал 2.9 сая төгрөг олгосон байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.”, Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 3 дугаар зүйлийн 3.3-т “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна.” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий 2 албан хаагчид шагнал, урамшууллыг холбогдох эрх зүйн акт зөрчиж, үндэслэлгүй олгосон нийт 6.2 сая төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Төсөвт батлагдаагүй, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, тэвчиж болох нийт 97.7 сая төгрөгийн гэрээг төсөвт өртгийг хувааж хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг 10 аж ахуйн нэгжтэй байгуулан, гүйцэтгэлээр 42.0 сая төгрөгийг олгож, үлдэгдэл 55.7 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.”, 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт батлагдаагүй, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлж, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Эдийн засгийн ангилал зөрчиж байр ашиглалтын үйлчилгээ арга хэмжээний бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж (210801) зардлын ангиллаас байрны засварын зардалд 85.7 сая төгрөг, шуудан илгээмжийн зардлаас шатахууны зардалд 2.0 сая төгрөгийг тус тус зарцуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 22 дугаар зүйлийн 22.9-т “Энэ хуулийн 22.6.8-д заасан ангиллаар тогтоосон төсвийг зүйл хооронд шилжүүлэн зарцуулах эрхийг төсвийн захирагчийн ангилал бүрээр тогтоох, томсгосон хяналтын түвшинг тогтоох нийтлэг журмыг Засгийн газар тогтоон мөрдүүлнэ.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн ангилал зөрчиж, зарцуулалт гарсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Тайлант онд 22.8 сая төгрөгийн шатахууны худалдан авалтыг хийж, үйл ажиллагаанд 18.2 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үлдэгдлээр 1 улирлын буюу 4.6 сая төгрөгийн шатахууны нөөц бүрдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримтлан шатахууны нөөц үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Тайлант онд 22,826.9 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг хийж, үйл ажиллагаанд 18,214.2 мянган төгрөгийг зарцуулж, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үлдэгдлээр 1 улирлын буюу 4,612.7 мянган төгрөгийн шаардлагагүй шатахууны нөөц бүрдүүлсэн байна.	1	4,612.7					1	4,612.7		
Шагнал, урамшуулалтай холбоотой нийт 6,165.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: 1. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн Б/219 дүгээр тушаалаар ажил байдлын тодорхойлолтод заагдаагүй, үндсэн чиг үүрэгт хамааралгүй асуудлаар 1 албан хаагчид үндэслэлгүй 1 сарын цалин буюу 3,303.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон; 2. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Б/245 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан 1 албан хаагчид жилийн эцсийн урамшуулал шагнал 2,862.4 мянган төгрөг олгосон байна.	1	6,165.4	1	6,165.4						
Төсөвт тусган төлөвлөөгүй, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг 10 аж ахуйн нэгжтэй төсөвт өртгийг хувааж нийт 97,700.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 42,000.0 мянган төгрөгийг зарцуулан, үлдэгдэл	1	55,700.0			1	55,700.0				

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

55,700.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.										
Эдийн засгийн ангилал зөрүүлж Байр ашиглалтын үйлчилгээ арга хэмжээний Бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж (210801) зардлын ангиллаас байрны засварын зардалд 85,730.1 мянган төгрөг, шуудан илгээмжийн зардлаас шатахууны зардалд 2,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	87,730.1			1	87,730.1				
Дүн	4	154,208.2	1	6,165.4	4	143,430.1	1	4,612.7		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн "Жилийн эцсийн урамшуулал олгох тухай" Б/233 дугаар тушаалаар улирлын дүнг бодитой, үндэслэлтэй үнэлээгүйгээр 312,754.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг урьдчилан үнэлж мөнгөн урамшуулал олгосон байна.	1	-			1	-
Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчид нь АА ангиллаар буюу бусад төрийн албан хаагчдаас өндөр цалингийн системтэй, мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэмд байцаагч нарт сар бүр урамшуулал олгох зохицуулалт байхгүй боловч Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Улсын байцаагчийн урамшуулал олгох журам"-ын дагуу сар бүр 15.0-30.0 хувийн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгож байна.	1	-	1	-		
Санхүүгийн зохицуулах хороо нь тайлант онд бүтэц, орон тоог бууруулах талаар өгөгдсөн чиглэлийг хэрэгжүүлээгүй, "Талант Бридж партнерс" ХХК-аас 19,000.0 мянган төгрөгийн зөвлөн туслах үйлчилгээ авч судалгаа хийлгэсэн боловч түүний үр дүн, зөвлөмжийг ашиглаагүй, цалингийн төсвийг тодотголоор бууруулсантай уялдуулан орон тооны зохицуулалт хийгээгүй байна.	1	19,000.0			1	19,000.0
Засгийн газраас баталсан улсын төсвөөс татварыг нь төлж байх олон улсын байгууллагын жагсаалтад тусгагдаагүй байгууллагын гишүүнчлэлийн төлбөрт 245,740.0 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөс төлсөн байна.	1	245,740.0	1	245,740.0		
Дүн	4	264,740.0	2	245,740.0	2	19,000.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 238/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/16/КА-СТА-ТЕЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Шагнал, урамшуулалтай холбоотой нийт 6,165,400.00 /зургаан сая нэг зуун жаран таван мянга дөрвөн зуу/ төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн Б/219 дүгээр тушаалаар ажлын байрны тодорхойлолтод заагдаагүй, үндсэн чиг үүрэгт хамааралгүй асуудлаар 1 албан хаагчид үндэслэлгүйгээр 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулалд 3,303,000.00 /гурван сая гурван зуун гурван мянга/ төгрөг;
- Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Б/245 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан 1 албан хаагчид жилийн эцсийн урамшуулал шагнал 2,862,400.00 /хоёр сая найман зуун жаран хоёр мянга дөрвөн зуу/ төгрөг тус тус олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.", Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн.” гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий 2 албан хаагчид шагнал, урамшууллыг холбогдох эрх зүйн акт зөрчиж, үндэслэлгүй олгосон нийт 6,165,400.00 /зургаан сая нэг зуун жаран таван мянга дөрвөн зуу/ төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга (Т.Жамбаажамц), Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч (Б.Нансалмаа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1365/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/16/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөвт батлагдаагүй, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, тэвчиж болох нийт 97,700,000.00 /Ерэн долоон сая долоон зуун мянга/ төгрөгийн гэрээг төсөвт өртгийг хувааж хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг 10 аж ахуйн нэгжтэй байгуулан, гүйцэтгэлээр 42,000,000.00 /Дөчин хоёр сая/ төгрөгийг олгож, үлдэгдэл 55,700,000.00 /Гавин таван сая долоон зуун мянга/ төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт батлагдаагүй, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлж, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга (Т.Жамбаажамц), Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч (Б.Нансалмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1366/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/16/НА-СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчид нь "АА" ангиллаар цалинждаг боловч Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэмд байцаагч нарт сар бүр урамшуулал олгох зохицуулалт байхгүй байхад Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Улсын байцаагчийн урамшуулал олгох журам"-ын дагуу сар бүр 15.0-30.0 хувийн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгож байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.", 45 дугаар зүйлийн 45.1-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн зарлагын хэмнэлтэд тооцно:", 45.1.5-д "энэ хуулийн 14.2.12, 16.5.9-т заасны дагуу зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн тогтоосны улмаас орон тоо буурсан бол түүнд ногдох цалин хөлс, бусад урсгал зардлын үлдэгдэл", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байцаагч нарт сар бүр үндэслэлгүйгээр урамшуулал олгож, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга (Т.Жамбаажамц), Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий няглан бодогч (Б.Нансалмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\1424 SAG-32 Docx

1526182196



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1367/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/16/НА -СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газраас баталсан улсын төсвөөс татварыг нь төлөх олон улсын байгууллагын жагсаалтад тусгагдаагүй байгууллагын гишүүнчлэлийн төлбөрт 245,740,000.00 /Хоёр зуун дөчин таван сая долоон зуун дөчин мянга/ төгрөгийг төсвийн хөрөнгөөс төлсөн байна.

Энэ нь Засгийн газрын 2007 оны 60 дугаар тогтоолоор баталсан "Олон улсын байгууллага, гэрээ, конвенцын итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай" тогтоолын Хавсралт 1 "Татварыг нь улсын төсвөөс төлөх олон улсын байгууллагуудын жагсаалт", 4-т "Цаашид олон улсын байгууллагад элсэх, олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орохдоо тухайн байгууллага, гэрээ, конвенцын ач холбогдол, хамтын ажиллагааны үр өгөөжийг сайтар судалж, гишүүний татвар, хандивыг Сангийн яамны саналыг үндэслэн улсын төсвөөс гаргах тохиолдолд энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр зөвшөөрөгдөж, жагсаалтад батлагдаагүй олон улсын байгууллагад гишүүнчлэлийн хураамж төлдөг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга (Т.Жамбаажамц), Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч (Б.Нансалмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

 С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga-2026\0424_SAG-32.Docx

1526182192



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1368/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/16/НА - СТА - ТЕЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Эдийн засгийн ангилал зөрчиж байр ашиглалтын үйлчилгээ арга хэмжээний бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж (210801) зардлын ангиллаас байрны засварын зардалд 85,730,124.00 /Наян таван сая долоон зуун гучин мянга нэг зуун хорин дөрөв/ төгрөг, шуудаг илгээмжийн зардлаас шатахууны зардалд 2,000,000.00 /Хоёр сая/ төгрөгийг тус тус зарцуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.9-д "Энэ хуулийн 22.6.8-д заасан ангиллаар тогтоосон төсвийг зүйл хооронд шилжүүлэн зарцуулах эрхийг төсвийн захирагчийн ангилал бүрээр тогтоох, томсгосон хяналтын түвшинг тогтоох нийтлэг журмыг Засгийн газар тогтоон мөрдүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулалт гарсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга (Т.Жамбаажамц), Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч (Б.Нансалмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН